

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2006 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### НИЙГМИЙН БОДЛОГО

*Боловсрол.* Монголын багш нарын 40 дэх өдрийн нэгдсэн арга хэмжээг тэмдэглэж оны тэргүүний цэцэрлэгээр нийт 7 цэцэрлэгийг шалгаруулж тус бүр нэг сая төгрөгөөр урамшуулснаас гадна тэргүүний багш нарыг шалгарууллаа.

Боловсролын мастер төлөвлөгөөний төслийг хандивлагчид, олон улсын байгууллагын суурин төлөөлөгч нарт танилцуулан хэрэгжүүлэх санхүүжилтийн талаар тохиролцлоо. Энэ нь мастер төлөвлөгөөг олон улсын байгууллагуудын зүгээс хүлээн зөвшөөрч, дэмжиж байгаагийн илрэл юм.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтын журмыг батлан хэрэгжүүлж байна. Энэ тушаалаар суралцагчид монгол хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, гадаад хэл, технологийн чиглэлээр шалгалт өгөх бөгөөд шалгалтыг чиглэл тус бүрээр, эсвэл нэгдсэн байдлаар авч болохоор зохицууллаа. Энэ нь үнэлгээн дэх төвлөрлийг сааруулж, суралцагчдын сурлагын амжилтыг явцаар нь үнэлэх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэснээс гадна сургуулиуд бие даан төгсөлтийн шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн ажил боллоо.

Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төлөвлөгдсөн ажлын эхлэл болгож "Цагаан толгойн эх"-ийг залах ёслолын ажиллагааг зохион байгуулсан нь үндэсний бичиг соёлоороо бахархах, өвлөн уламжлуулахад түүхэн ач холбогдолтой юм.

Их ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж байгаа "Чингис хаан ба түүний өв залгамжлагчид" үзэсгэлэнгийн хаалтын ёслолын ажиллагааг ХБНГУ-ын Мьонхен хотноо хийж, Австри Улс руу шилжүүллээ. Уг үзэсгэлэнг Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг угтаж тус явагдах Монголын соёлын өдрүүдийн үеэр гаргах бөгөөд нээлтийг энэ оны 4 дүгээр сард хийнэ.

Эрдэм шинжилгээний залуу ажилтан нараас грант горилж ирүүлсэн бүтээлийг шалгаруулж нэр бүхий 10 эрдэмтэнд тус бүр 2 сая төгрөгийн грантыг олголоо. Ингэснээр төрийн зүгээс залуу эрдэмтдийг урамшуулах, тэдний бүтээлийг амьдралд нэвтрүүлэх, нийгмийн сайн сайхан, хүн, малын эрүүл мэндийн төлөө ашиглах боломжийг нь дэмжсэн хэрэг юм.

*Нийгмийн хамгаалал.* Нийгмийн халамжийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор "Амьжиргаанд туслах халамжийн хөтөлбөр", "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн хөтөлбөр", "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөр"-ийг эцэслэн боловсруулав. "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөтөлбөр" нь орон нутаг дахь эмзэг бүлгийн өрх, иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор өрх гэр бүл, хувь хүний санаачилга сонголтонд суурилсан олон талт үйлчилгээг түвшин тус бүрт үзүүлэх юм.

"Амьжиргаанд туслах халамжийн хөтөлбөр" нь хуульд хамрагдах нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд олгох тэтгэвэр, тэтгэмж, нөхцөлт мөнгөн тэтгэмж, амьжиргааг дэмжих хөнгөлөлт, тусламж үйлчилгээний төрлүүдийн нийгмийн халамжийн үйлчилгээг олгоход баримтлах хөтөлбөр юм. "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөр" нь мэргэжлийн үйлчилгээ шаардлагатай нэн эмзэг бүлгийн иргэдийн хэвийн амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэх болно.

2006 оны 2 дугаар сарын 1-нээс төрийн албан хаагчдын цалинг 30.0 орчим хувиар, ахмад настны халамжийн тэтгэврийг 30 хувиар тус тус нэмэгдүүлэх, 120.0 мянган төгрөгөөс дээш тэтгэвэр авагчдын тэтгэврийн дээд хязгаарыг арилгах асуудлыг УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлжээ.

*Хүн амын хөгжил.* Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх 2 дугаар шатны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн төслийг батлуулав. 2005-2008 онд хэрэгжүүлэх энэхүү үндсэн чиглэлд боловсролын түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжид жендэрийн тэгш байдлыг тусган боловсронгуй болгох, хөдөөгийн хүн амын дунд бизнесийн сургалт зохион байгуулах, залуучууд,

эмэгтэйчүүдийг удирдлагад бэлтгэх сургалт зохион байгуулах, ТББ-уудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг 18 томоохон ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан байна

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Хүүхэд хамгаалал төслийн 2006 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, төрийн болон ТББ-ууд хүүхэд хамгааллын талаар хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцлаа. “Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн зорилгоор ашиглах, худалдахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд орон нутаг, үндэсний түвшинд олон нийт, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах, сургалт, ухуулга сурталчилгааны ажилд түлхүү анхааран ажиллах, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулах зэрэгт гол ач холбогдол өгч хамтран ажиллахаар боллоо.

*Хөдөлмөр эрхлэлт.* Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид, малчдыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах, хөдөлмөр эрхлэлтийн шинэ үйлчилгээ, арга хэмжээг нэвтрүүлэх чиглэлээр хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг өргөжүүлснээр уг арга хэмжээнд жилд 21290 иргэн үүнээс 3.5 мянган малчин, 3.0 мянган албан бус хөдөлмөр эрхлэгч, 9.0 мянган эмзэг бүлгийн иргэд нэмж хамрагдах боломжтой болох юм.

“Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг батлуулав. Энэхүү бодлого батлагдсанаар албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалт, арга зүй зэрэг төрийн үйлчилгээгээр дамжуулан албажих боломжийг бүрдүүлэх, тэдгээрийг эрсдлээс хамгаалах эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгааг бий болгон улмаар улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж хөдөлмөр эрхлэлтийг тоо, чанарын хувьд сайжруулан хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломж бүрдэж байгаа юм.

*Эрүүл мэнд.* Сувилахуйн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, ЭМЯ-ны сувилагчийн зөвлөлийн бүрэлдэхүүн, аймаг, нийслэлийн сувилагчийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлан мөрдүүлэв.

Дэлхийн Вакцины сангийн “Аюулгүй дархлаажуулалт” төслийн шугамаар ирсэн тоног төхөөрөмж, Японы олон улсын хамтын ажиллагааны шугамаар нийлүүлэгдсэн гүйдэл тохируулагч, вакцин зөөвөрлөх сав, аюулгүй хайрцаг, Вакцин дархлаажуулалтын глобаль альянс байгууллагын хүрээнд нийлүүлэгдсэн зүүт тариур, дархлаажуулалтын сангийн шугамаар нийлүүлэгдсэн вакцин зөөвөрлөх сав, хүүхдийн байгууллагын голомтод шаргүй далд хэлбэрийг эрт илрүүлэх уранализийн оношлуурыг хуваарилав.

Баянхонгор аймгийн Жаргалант, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Говь-Алтай аймгийн Бигэр сум, суурингийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, санарыг сайжруулах зорилгоор дээрх сумын эмнэлгийг сум дундын эмнэлэг болгов.

Нийслэлийн 6 дүүргийн 12 цэцэрлэгт томуугийн өвчлөлтэй холбогдуулан 7 хоног ирцийн тандалт хийлээ.

Томуугийн өвчлөл өндөртэй байгаа Архангай, Завхан, Говь-Алтай, Дорнод аймгуудад өрхийн эмнэлгийн үзлэгийг гэрийн үйлчилгээнд шилжүүлэх, түргэн тусламжийн эмч, унааг нэмэгдүүлэх хүүхдийн зарим байгууллагуыг түрхааха талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна.

2005 оны жилийн эцсийн байдлаар 45192 эх төрж, 42 эх эндсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 5.8 хувиар буурсан байна. 2005 оны жилийн эцсийн байдлаар амьд төрсөн хvvхдийн тоо 2005 онд 45.2 мянга болсон нь 2004 оныхоос 1.5 хувь буюу 650 хvvхдээр өссөн байна. Нэг хvртэлх насандаа нас барсан хvvхдийн тоо 938 болж 2004 оныхоос 7.7 хувь буюу 78 хvvхдээр, 1-5 хvртэлх насандаа эндсэн хvvхдийн тоо 239 болж, 2004 оныхоос 14.6 хувь буюу 41 хvvхдээр тус тус буурчээ.

Харин халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 32.3 мянга болж, 2004 оныхоос 1.0 мянгаар нэмэгдсэн байна. 2005 онд ХДХВ/ ДОХ-ын нийт 11 тохиолдол бүртгэгдээд байна.

## ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулав. Энэхүү хуулиар Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох мэргэжлийн зөвлөлийг татан буулгаж, түүний гүйцэтгэж байсан чиг үүргийг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргазүйн хэлтэс, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд хариуцуулж, аудитын компани, аудитор нарын эрх үүргийг улам тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүллээ.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулсан “Орон нутгийн зам сайжруулах” төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай, Монгол Улсын Засгийн газар, Шведийн Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн хооронд байгуулсан “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах” төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай хуулийг батлуулав.

Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль, орчныг хамгаалах хоёр үе шаттай зээл”-ийн хэлэлцээрт гарын үсэг зурахаар боллоо. Япон Улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр төсөл хэрэгжүүлэхэд зориулан 25.9 сая ам.доллартай тэнцэх иенийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор төлөвлөсөн байна.

- 2005 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого **833.3** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 92.0 тэрбум төгрөгөө давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 136.0 тэрбум төгрөгөөр /19.5 хувь/ өсчээ.
- Улсын хэмжээнд 2006 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар нийт авлага **5.9** тэрбум, нийт өглөг **4.8** тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан дүн мэдээтэй байна.
- Улсын төсвөөс 1110 төсөвт байгууллагын 2006 оны 1 дүгээр улирлын зардалд зориулан **99,3** тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон.
- 2006 оны 1 сард Засгийн газрын нөөц хөрөнгөөс 91,4 сая төгрөг (тухайн сард 91,4 сая төгрөг), улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас 10,9 сая төгрөг (тухайн сард 10,9 сая төгрөг) зарцуулсан байна. Мөн 2006 оны 1 сард орон нутагт олгох НӨАТ-н шилжүүлгээр 1499.9 сая төгрөг (тухайн сард 1499.9 сая төгрөг), санхүүгийн дэмжлэгээр 632.0 сая төгрөг хуваарилан олгов.
- Засгийн газар 2006 оны 1 сард (өссөн дүнгээр) гадаад зээлийн үндсэн төлбөрт 467.8 сая төгрөг, хүүгийн төлбөрт 275.9 сая төгрөг, нийт **743.7** сая төгрөг төллөө. Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 892,3 сая төгрөг, хүүгийн төлбөрт 107,7 сая төгрөг, бүгд **1.0** тэрбум төгрөг төлөв. Засгийн газраас 2006 онд гаргах үнэт цаасны тухай УИХ-ын тогтоолыг батлуулж, 2006 онд 80 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас борлуулах зөвшөөрөл авлаа.

Худалдан авах ажиллагааны анхан шатны сургалт зохион байгуулах, сертификат олгох түр журмыг баталлаа. Энэхүү журмаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай шинэ хуулийг мөрдүүлэхтэй холбогдуулан захиалагч байгууллагын боловсон хүчний үндсэн чадавхийг богино хугацаанд бүрдүүлэх, мэргэшүүлэхэд туслалцаа үзүүлэх ажлыг зохицуулах юм.

Дэлхийн банкны “Худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд томоохон захиалагч байгууллагад зориулан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” сэдвээр худалдан авах ажиллагааны анхан шатны сургалтыг Худалдан авах ажиллагааны хөгжлийн төвтэй хамтран зохион байгууллаа.

Японы Засгийн газраас Монгол Улсад үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд Төслийн бус буцалтгүй тусламжийн шугамаар 330 сая иений улаан буудай олгох гэрээг гүйцэтгэх засаглалын байгууллагын шийдвэрийг стандартчилах, олон нийтэд нээлттэй, хүртээлтэй болгох зорилго бүхий 295.0 мянган ам.долларын өртөгтэй “Захиргааны дүрэм, журмыг стандартчилах буцалтгүй тусламжийн төслийн гэрээг тус тус байгуулж, хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулсан.

Үйлдвэрлэл. Оёмол, сүлжмэл эдлэлийн үйлдвэрийн нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг улсын төсвийн хуваарилагдаагүй зарлаас нөхөн олгох журмыг батлан, мөрдүүлэв. Энэ журмаар ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын төлбөрийн нөхөн олговрын хэмжээг 3-5 жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан бол 40 хувь, 5-аас дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан бол 50 хувь байхаар тогтоолоо.

Худалдааны гол түнш орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах Монгол Улсын "Roadmap"-ын талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Пиво, ундааны лаазыг татваргүйгээр экспортлох асуудлыг шийдвэрлүүлэв.

Бүсийн зөвлөлийн дарга нартай Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих технологи хөгжлийн санг орон нутагт хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулан ажиллаж байна.

Монголын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөлийн удирдах зөвлөлийн ээлжит хурал, Арьс ширний үйлдвэрлэгчдэд Цэвэр үйлдвэрлэлийн зарчмыг нэвтрүүлэх сургалт семинарыг тус тус зохион байгуулав.

Газрын тосны тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон Засгийн газраас баталсан Бүтээгдэхүүний хуваах гэрээний хэрэгжилтийн асуудлаар уулзалт зохион байгуулав.

ҮХЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газар хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн VI хуралдааны протоколыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр Шаньси мужийн Таюань хотын Уул уурхайн компанитай хамтран ажиллах талаар протокол байгуулав. Мөн ӨМӨЗО-ны Худалдааны танхимын удирдлагуудтай байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн протоколыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, ажлын дэд хэсгүүд байгуулах талаар харилцан санал солилцож, хоёр талд худалдаа, хөрөнгө оруулалтын төв байгуулах ажлыг эхлүүлэх чиглэлийг тогтоов.

## БАЙГАЛЬ ОРЧИН

"Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүллээ.

"Хус бэлтгэхийг зогсоох тухай", "Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай" тушаалуудыг гарган мөрдүүлж байна.

Худалдаа аж үйлдвэрийн танхим, Цэвэр үйлдвэрлэлийн төвтэй хамтран арьс ширний үйлдвэрүүдийн удирдлагуудыг оролцуулсан цэвэр үйлдвэрлэл, усны бохирдлыг бууруулах, цэвэршүүлж үнэлгээ хийх аргачилалаар сургалт семинар зохион байгуулав.

Богдхан уулын дархан цаазат газар, Хустайн байгалийн цогцолборт газар, Батхаан уулын нөөц газар, тэдгээрийн хоорон дахь салбар уулсын халиун бугын тархац нөөцийн хээрийн судалгааг ШУА-ын Биологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулав.

2006 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг хэрэглээний мод 29.0 мянган шоо.метр түлээний мод, 570.0 мянган шоо.метрээр тогтоолоо.

Байгаль орчны шинжилгээний төв лаборатори нь энэ сард Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуулаас, нийт 154 сорьц авч, хүхэрлэг хий болон азотын давхар исэл гэсэн 2 үзүүлэлтийг шинжлэн тодорхойлов. Шинжилгээний дүнгээс харахад хүхэрлэг хийн дундаж агууламж хамгийн ихдээ 0.071 мг/м<sup>3</sup> хүрч, нийт 79 удаагийн ажиглалтаас агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 25 удаа давсан бохирдол ажиглагдсан байна.

Голын усан дахь ахуйн гаралтай органик бодисын бохирдол ихэсч, аммоны азот /NH<sub>4</sub>-N /-ын агууламж усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 16-35 дахин их, нитритын азот /NO<sub>2</sub>-N /-ын агууламж 1.4-2.5 дахин их, эрдэс росфор /P/ -ын агууламж 7-17 дахин их, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ<sub>5</sub>/ 13.- 33 дахин ихээр тус тус давсан байна.

## ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО

“Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөг шинэчлэх, Улаанбаатар болон бусад томоохон хотуудын орон зайн мэдээллийн санг бүрдүүлэх”, “Монгол орны малчин өрх бүрийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээр хангах” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх талаар Япон Улсын Засгийн газар, Дэд бүтцийн яамтай хамтран ажиллахаар тохиролцов.

“40000 орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд баригдах шинэ хотхон, хорооллуудын газрын асуудлыг шийдвэрлүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Мөн энэ ажлын хүрээнд “Богд хан” уулын тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсэд өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллаж байна.

Залуу гэр бүл, бага, дунд орлоготой өрхөд зориулсан нэг маягийн орон сууцны барилгын загвар төсөл сонгон шалгаруулах уралдааныг зохион байгуулав. Орон сууц хөгжүүлэх сангаас төрийн албан хаагчдад зээл олгох шалгуур үзүүлэлтийг батлуулав.

Гэр хорооллын нөхцөл сайжруулах төслийн зээлийг олгох гэрээг байгуулаад байна.

Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 200 айлд дулааны алдагдал багатай гэрийн бүрээсийг “Дулааны хэмнэлттэй хувийн орон сууцыг зах зээлд нэвтрүүлэх төсөл”-өөс олгуулав.

*Зам тээвэр.* Тэргүүлэх ач холбогдол бүхий замын чиглэл болох “Өндөрхаан-Сүмбэр-Нөмрөг чиглэлийн 660 км авто замын төсөл”, “Баруун бүсийн авто замын Улаанбайшинт-Өлгий-Ховд чиглэлийн 533 км замын төсөл”-ийн саналыг боловсруулан Японы талд хүлээлгэн өгөв.

“Автозамын дагуух үйлчилгээний байгууламжийн стандарт”-ыг батлуулан мөрдүүлэв.

“Тээвэр сэргээх төсөл”-ийн хүрээнд нийлүүлэгдсэн автобус, троллейбус, тэдгээрийн сэлбэгийн үнэ болох 9.5 сая долларын өрийг төсвийн хөрөнгө оруулалтад тооцох, нийтийн зорчигч тээврийн төрийн өмчит компаниудын нийгмийн даатгалын шимтгэлд төлөх 200.0 сая төгрөгийг улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас олгох, Япон Улсын буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн автобусуудыг сэргээн засварлахад зориулан хөрөнгө оруулалт хийх, том оврын автобусыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлуудыг шийдвэрлүүлэв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нийсэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дотоод үйл ажиллагаа, гадаад хамтын ажиллагаа, аж ахуйн болон эрх зүйн үйл ажиллагааг нэгдмэл удирдлагаар хангах, аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтад тавигдах хяналтыг сайжруулах зорилгоор Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанд Ерөнхий менежерийн орон тоог шинээр бий болгов.

“Марк, үнэт цаас үйлдвэрлэх, борлуулах журам”-ыг батлуулав. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан “Чингис хааны үеийн зоос” нэртэй маркийг хэвлүүлэн гүйлгээнд гаргалаа.

Герман Улсын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийг УИХ-аар соёрхон батлуулав.

“Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, улсын төсөвт орох төлбөр болох 51.5 мянган ам.долларыг Тээврийн үйлчилгээний төвийн дансанд төвлөрүүлэв.

*Аялал жуулчлал.* “Шинэ оны анхны нар харах аялал” зохион байгууллаа. Арга хэмжээнд 500 гаруй жуулчид оролцсоноос 120 нь гадаадын жуулчид байв.

Өвлийн болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Адал явдалт спорт аяллын холбоотой хамтран “Цэвэр цас-цэнгэг агаар” сэдэвт насанд хүрэгчдийн өвлийн спорт аяллыг Богдхан уул, Хэнтийн нуруу-Хагийн хар нуур чиглэлд зохион байгуулав.

*Эрчим хүч.* Сар шинийн баярын үеэр түлш, эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах үүднээс хариуцлагатай эргүүл томилон, найдвартай ажиллагаанд салбарын хэмжээнд өндөр үүрэг хариуцлага үүрч ажилласны дүнд сар шинийн баярын үеэр ямар нэгэн тасалдал саатал, осол авааргүй, хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар найдвартай хангаж ажиллалаа.

“Төвийн бүсийн цахилгаан дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах төсөл”-д Шведийн Засгийн газраас олгох зээлийн хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлууллаа.

Багануурын дулааны станцын VII зуухыг ажиллагаанд залган явуулах үед зууханд тэсрэлт гарч, дулааны шугам сүлжээнд усан цохио үүссэн тул станц зогсож, Багануур хот хөлдөх аюул нүүрлэсэн аварийн үед газар дээр нь шуурхай удирдлагаар ханган ажилласны дүнд станц, дулааны сүлжээний ажиллагааг богино хугацаанд сэргээж хэвийн болгов.

“100000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг дэмжих эргэлтийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журмыг боловсруулаад байна.

АНУ-ын ОУХА-ын Эрчим хүчний зөвлөх Хорст Мейнэкийг хүлээн авч уулзаж Эрчим хүчний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, Сэргээгдэх эрчим хүчний хуулийг УИХ-д өргөн барих, Эрчим хүчний салбарын хэтийн төлөв буюу Цагаан номыг боловсруулан гаргах талаар санал солилцлоо.

*Хөдөө аж ахуй.* Ган, зуд зэрэгэшт байгалийн гамшигт үзэгдлээс болж 1999-2002 онд мал хорогдсоноос 333 тэрбум төгрөгийн шууд хохирол манай улсын эдийн засагт учирчээ. Үүнээс үүдэн Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банк, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага зэрэг олон улсын хандивлагч нартай хамтран Монгол орны зах зээлийн судалгааг 2001 оноос эхлэн хийж, өнөөгийн нөхцөлд индекст суурилсан малын даатгалын хэлбэрийг манай улсын хувьд тохиромжтой болохыг сонгожээ. Тийнхүү манай Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн эссоциацийн хооронд "Малын индексжүүлсэн даатгал төсөл"-ийн хөгжлийн зээлийн гэрээ байгуулагдаж, төсөл өнгөрсөн оноос хэрэгжиж эхэлсэн. 2009 он хүртэл үргэжлэх туршилтын хугацаанд Увс, Баянхонгор, Хэнтий аймаг хамрагдаад байгаа юм. Энэ даатгалаар индекст суурилсан буюу тодорхой нутаг дэвсгэрийн статистик үзүүлэлтэд үндэслэн даатгалын хохирол, нөхөн төлбөрийн хувь хэмжээг тооцоолох аргыг бэлчээрийн мал аж ахуйд туршин нэвтрүүлэхээр зорьж байгаа юм. Төслийн үр дүнгээр малчдын амьжиргаа дээшилж, даатгалын компаниудад зах зээлийн зарчмаар хөгжих боломж нээгдэж байгаа нь байгалийн гамшгийн үед Засгийн газарт ноогдох ачааг хөнгөвчлөх юм.

“НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа. Махыг нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх нь хавар махны үнэ хөөрөгдөхөөс сэргийлэх нэг арга хэмжээ болох бөгөөд махны үнэ огцом өссөн гол шалтгааны дотор махны үйлдвэрүүд нэмэгдсэн өртгийн албан татвараас зайлсхийхийн тулд экспортод хямд үнээр мах гаргаж байна гэж үзэн махны үйлдвэрүүдийн боловсруулж дотооддоо борлуулсан махыг НӨАТ-аас чөлөөлснөөр махны үнийн өсөлтийг бууруулах, улмаар түүний хангамж сайжрах нэг боломж бүрдэх юм.

Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжих “Санхүүгийн чадвар муутай ядуу фермерүүдэд дэмжлэг үзүүлэх КР-2” төслийн НОТ бичигт гарын үсэг зурж, энэ оноос эхлэн хэрэгжихээр болов.

2005 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, оношлох биобэлдмэл, бүтээгдэхүүн худалдаж авахаар “Биоүйлдвэр” УҮГ-тай байгуулсан гэрээг дүгнэв. Мөн тус үйлдвэрээс 2006 онд бүтээгдэхүүн худалдан авах гэрээг байгуулав. 2006 онд Мал эмнэлгийн хүрээлэнгээс био оношлуур худалдан авах гэрээ байгуулав.

Шүлхий өвчнөөс сэргийлэх, вакцины хүчдэл тогтоох, цусны ийлдсийн дээжийг авах талаар албан даалгавар гаргалаа. Шүлхий өвчнөөс сэргийлэх тарилгад хамрагдсан малд вакцины дархлаа, түүний хүчдэл тодорхойлох зорилгоор дээж авах аргачлал, түүнийг хэрэгжүүлэх албан даалгаврын хамт Улаанбаатар, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад хүргүүлэв.

Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Хөвсгөл аймагт галзуу өвчин гарсантай холбогдуулан тус бүр 5 мянган тун вакцин нийлүүлэв.

ХААЯ-ны төлөөлөгчид ХБНГУ-д явагдсан “Ногоон долоо хоног - 2006” Олон улсын үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож, Монголынхоо хүнсний зарим нэрийн бүтээгдэхүүнийг таниулж, сурталчиллаа.

*Харилцаа, холбоо.* Замын-Үүд-Улаанбаатар-Сэлэнгийн өндөр хурдны улс хоорондын болон хот хоорондын үндсэн сүлжээ байгуулах төсөл боловсруулах ажлын хүрээнд БНХАУ-ын “Huawei” компаний мэргэжилтнүүдтэй хамтран өндөр хурдны шилэн кабелийн “DWDM” системийг улс хоорондын, “SDH” системийг хот хоорондын сүлжээнд байгуулах төслийг боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцоог гаргаад байна.

“Багануур-Мөнгөнморьтийн хооронд LDDL утасгүй дамжуулах системийг ашиглан Интернэтийг хүргэх” туршилтын төслийн явцад анализ хийсэн. Шаардлагатай нэмэлт арга хэмжээ авах асуудлаар Монголын Цахилгаан холбоо ХК, МИКОМ компанитай хамтран нарийвчилсан судалгаа хийж байна.

Олон улс руу холбогдох интернэтийн нэгсэн гарцыг бий болгож, зурвасыг өргөтгөх замаар холболтын үнэ тарифыг бууруулж, интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай байгуулсан гэрээ, санамж бичгийн дагуу хамтран ажиллаж байна. Интернэтийн олон улсын хурдны үнийг 392 ам.доллар болгосон арга хэмжээний нээлтийг зохион байгуулав.

“Дашинчилэн-Булганы шилэн кабелийн дамжуулах сүлжээ байгуулах” төсөл хэрэгжүүлсэнтэй холбогдуулан МЦХ ХК-ий дамжуулах байгууламжийн сүлжээний төв дээрээс тоон радио релейний NMS сигналыг Дашинчилэнд суурилуулсан ZTE компаний S380 төхөөрөмжөөр хянаж, удирдах ажлыг дуусган удирдлагын хянах байгууламжуудыг ашиглалтад хүлээлгэн өглөө.

## ГАДААД БОДЛОГО

*Батлан хамгаалах.* Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжилтийг ханган манай улсад хадгалагдаж байгаа газрын минийн асуудлыг үе шаттай ил болгохоор “Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулав.

Монгол Улсад цэрэг техникийн тусламж үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын БХЯ, ОХУ-ын “Конструкторское бюро приборостроение” ТӨҮГ хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн зэвсэг, галт хэрэглэлийг зэвсэглэлд нэвтрүүлэх тухай Батлан хамгаалахын сайдын тушаалын хэрэгжилтийг зохион байгууллаа.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн V ээлжийн бүрэлдэхүүн “Эко” баазад, Косово дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй Олон үндэстний зүүн хойд дивизийн Митроцива хотод байрлах Францын батальоны бүрэлдэхүүн дэх Бельгийн Вант Улс, Люксембург Улс, Монгол Улсын хамтарсан ротын бүрэлдэхүүнд манай цэргийн багийнхан, “Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэж байгаа сургалтын хөдөлгөөнт багийн V ээлжийн бүрэлдэхүүн тус тус үүргээ амжилттай хэрэгжүүлж байна.

Сиерра Леоне Улсад явуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй Зэвсэгт хүчний цэргийн багийнхан тус улсын Фрийтаун хот дахь НҮБ-ын Нарлаг баазад байрлан уг бааз болон Тусгай шүүх дээр 2 хуваагдан үүрэг гүйцэтгэж байна.

*Гадаад бодлого.* Гадаад хэргийн сайд БНЭУ-д албан ёсны айлчлал хийж, БНЭУ-ын ЭСЯ-нд газар түрээсээр ашиглуулах тухай, Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визээс харилцан чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Дархан-Уул аймагт Монгол-Энэтхэгийн эрдэм шинжилгээ, судалгааны хамтарсан найрамдал агропарк байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус байгууллаа.

Германы Бундестагийн Гадаад бодлогын байнгын хорооны гишүүн М.Грунд Монгол Улсад ажиллаж, Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ-ын зарим гишүүд, Гадаад хэргийн дэд сайд болон намуудын дарга нартай уулзав.

Афганистаны Кабул дахь НАТО-гийн “Аюулгүй байдлыг дэмжих олон улсын хүч”-ний төвд Туркийн батальоны бүрэлдэхүүнд манай улсын цэргийн бие бүрэлдэхүүнийг

оролцуулах хүсэлтийг туркийн тал манай БХЯ-нд тавьсны дагуу асуудлыг судалж, хариу өгөхөөр ажиллаж байна.

Монгол, Хятадын хилийг хоёр дахь удаагаа хамтран шалгасан тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын протокол, хоёр улсын хилийн зурвас газрын зургийг соёрхон батлуулахаар УИХ-д өргөн барилаа.

Солонгосын Шинхан банк Солонгост байгаа монгол иргэдийн мөнгийг Монгол руу албан ёсоор гуйвуулж байхаар болов. 2000 хүртэл ам.доллар гуйвуулахад банкны шимтгэл 18000 вон байдаг бол “Шинхан” банк манай иргэдэд хөнгөлөлт үзүүлж 9000 вонгоор үйлчлэх, шилжүүлгийн мэдүүлгийн монгол хэл дээрх загварыг бүх салбарууддаа тавихаар боллоо.

## ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Сэлэнгэ мөрөн, Онон, Балж голын урсацад тохируулга хийх санал боловсруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд санал өгч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

“Эргүүл хамгаалалтын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Завхан аймгийн Цагдаагийн газрын албаны конторын асуудлыг шийдвэрлэх тухай”, Япон Улсын Засгийн газрын хуулийн зөвлөхөөр ажилласан Английн “Ричард Батлер” компанийн өмгөөллийн хөлсийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргах тухай зэрэг асуудлыг шийдвэрлэлээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Санхүүгийн түрээсийн тухай зэрэг 7 хуулийн төсөл, “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалт батлах тухай”, “Үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” зэрэг УИХ-ын 3 тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олголоо.

Ашигт малтмал гар аргаар олборлох тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг 8 хуулийн үзэл баримтлалыг батлаад байна.

Манай Улсад хууль бусаар оршин суугаа гадаадын иргэд /харьяалалгүй хүн/-ийн бүртгэл, хяналт болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт болон төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авч байна.

*Шударга бус өрсөлдөөнийг хянах.* Харилцаа холбоо, мэдээллийн технологийн зах зээлд давамгайл байдлыг тогтоох нарийвчилсан аргачлалыг батлав.

Түлшний зах зээлийн нүүрс олборлолт, төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хийсэн судалгаа, дүгнэлтийг үндэслэн түлшний салбарын нэр бүхий 16 аж ахуйн нэгжийн давамгайл байдлыг тогтоов.

Төмөр замын тээврийн зах зээл дэх Орос-Монголын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам нийгэмлэг”-ийг зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгжээр тогтоов.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

----- о О о -----